

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

**ЗЭВСЭГ ХУРААХ II ТУСГАЙ ЧУУЛГАНЫ
ТУХАЙ****Б. Дашцэрэн****Р. Отгон, түүхийн ухааны дэд эрдэмтэн**

Империалист харгис хүчин зэр ээвсгийн талаар давуутай болохыг эрмэлзэн зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг улам гааруулах шатлан өсгөсний улмаас олон улсын байдал эрс хурцадсан хийгээд цөмийн хязгаарлагдмал дайныг хийж болох тухай болон цөмийн зэвсгийг хэрэглэх явдлыг номолсон бусад номнол, онолуудыг гаргаж ирсэн нь юуны өмнө хүн төрөлхтнийг цөмийн сүйрлээс аврах, цөмийн дайныг сэрэмжлэн зайлуулахад чиглэгдсэн арга хэмжээг даруй авах хойшлуулшгүй шаардлагын үүднээс зэвсэг хураах II тусгай чуулганыг НҮБ-аас зарлан хуралдуулсан юм.

Зэвсэг хураах асуудал хэлэлцсэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хоёрдугаар тусгай чуулган 1982 оны зургадугаар сарын 7-ноос долдугаар сарын 10-нд хуралдсан нь дэлхийн олон нийтийн анхаарлыг зүй ёсоор татсан билээ.

Зэвсэг хураах асуудлыг 1978 онд дангаар хэлэлцсэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн анхдугаар тусгай чуулганаас гаргасан Төгсгөлийн баримт бичигт дэлхийн дайн, ялангуяа цөмийн дайны аюул заналыг сэрэмжлэн зайлуулах явдал орчин уеийн хамгийн тулгамдсан нэн тэргүүний зорилт мөн гэж тэмдэглэсэн нь өнөөгийн олон улсын байдал хурцадсан үед улам ч чухал ач холбогдолтой болж байна.

АНУ тэргүүтэй империалист харгис хүчин өнөө үед тогтоод байгаа цэрэг-стратегийн тэнцвэрт байдлыг өөртөө ашигтайгаар өөрчилж, социалист ертөнцөөс цэргийн хүчээр давуутай болохыг эрмэлзэн, үүний тулд зэвсэглэлээр, нэн ялангуяа цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг урьд үзэгдээгүй хэмжээгээр ихэсгэв.

АНУ цөмийн зэвсгийн нөөцөө шинэчлэх иж бүрэн программыг боловсруулж байгаа бөгөөд үүнийгээ Европын холбоотнууддаа тулган хүлээлгэх оролдлого хийж байна. Үүнийг тусгай чуулганы өмнөхөн хуралдсан НАТО-гийн гишүүн улсуудын удирдагчдын зөвлөлгөөн, түүнээс баталсан «Бонны тунхаглал» гэгч нь гэрчилж байна. Зэр зэвсгийн хүчин чадлыг цаашид нэмэгдүүлэхэд чиглэсэн энэхүү Тунхаглалын үзэл санаа зэвсэг хураах асуудлаар II тусгай чуулганд оролцсон өрнөдийн төлөөлөгчдийн үйл ажиллагааны үндсэн чиг шугам болсон нь тодорхой харагдлаа. Тэд зэвсэг хураахад чиглэсэн ямар нэг шийдвэрийг тусгай чуулганаас гаргуулахгүй байх, энэ салбарт ажил хэрэгч яриа хэлэлцээ явуулахад бүхий л талаар саад хийх байр суурь баримтлав. Үүний уршгаар тус чуулганаас тодорхой баримт бичиг боловсруулан гаргаж чадаагүй юм.

ЗХУ, социалист бусад орон зэвсэглэлээр хөөцөлдөхийг хязгаарлах, зэвсэг хураах гол үндсэн чиглэлүүдээр тэгш эрх, адил тэгш аюулгүй

байдлын зарчмыг хүндэтгэн сахих үндсэн дээр буурьтай хэлэлцээ явуулж бодит тодорхой арга хэмжээ авах, цөмийн дайны аюул заналыг зайлуулах шийдвэр гаргах явдлыг тусгай чуулганы эн тэргүүний зорилт болгон дэвшүүлж түүнийг хэрэгжүүлэхийн, төлөө их хүчин чармайлт гаргав.

Л.И.Брежневээс II тусгай чуулганд ирүүлсэн илгээлтэд зааснаар ЗСБНХУ түрүүлж цөмийн зэвсэг хэрэглэхгүй байх үүрэг авч байгаагаар тус чуулганы индэр дээрээс зарлан тунхагласан нь ЗХУ манай дэлхийн хувь заяаны төлөө, дэлхийн иргэншил, хүн төрөлхтний жаргалант ирээдүйн төлөө хичнээн их санаа тавьж байдаг болон энэ ертөнцийн энх ам-галан байдлыг хангахын төлөө хичнээн өндөр хариуцлагатай хандаж байдгийн тод нотолгоо болов. БНМАУ-ын Гадаад явдлын яамны сайд М. Дүгэрсүрэн тус чуулган дээр хэлсэн үгэндээ «Түүхэн ач холбогдолтой энэ үлгэр дууриалыг цөмийн зэвсэгтэй бусад гүрэн дагах юм бол цөмийн зэвсэг хэрэглэх явдлыг уг чанартаа бүрмөсөн хориглож, улмаар зэвсэг хураах үйл хэргийг урагшлуулах таатай угтвар нөхцлийг бүрэлдүүлэхсэн билээ»¹ гэж онцлон тэмдэглэсэн юм.

Цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах үйл хэрэгт алхам болж, хүн төрөлхтний хувь заяаны асуудалд буурьтай хандах шаардлагатай байгаагийн үлгэр дууриал болсноороо ЗХУ-ын энэ шийдвэр түүхэн ач холбогдолтойг тусгай чуулганд оролцогчдын дийлэнх олонхи сайшаан дэмжлээ.

ЗХУ зэвсэг хураах үйлст ахиц гаргах зорилгоор цөмийн дайны аюулыг зайлуулах зэвсгээр хөөцөлдөх явдлыг зогсоох асуудлаар меморандум бэлтгэж II тусгай чуулганд орууллаа.

Энэхүү меморандумд зэвсэглээр хөөцөлдөх явдлыг хазаарлан зогсоох, ялангуяа цөмийн зэвсгийг хураах программыг шат дараалан биелүүлэх талаар тодорхой арга хэмжээ боловсруулах ба авахтай холбогдсон зарчмын болон ажил хэргийн ач холбогдол бүхий санал дэвшүүлсэн юм.

Социалист орны төлөөлөгчид чуулган дээр энх тайвныг бэхжүүлэх намжмал байдлыг сэргээн буй болгох, зэвсгээр хөөцөлдөх явдлыг эцэс болгох, олон улсын хамтын ажиллагаа, харилцан ойлголцох явдлыг бэхжүүлэхэд чиглэсэн бүхэл бүтэн оновчтой саналуудыг дэвшүүлсэн билээ.

ЗХУ-аас цөмийн зэвсгийг урьдаж хэрэглэхгүй хэмээн зарласан тунхаглал, Зөвлөлт засгийн газрын меморандумд дэвшүүлсэн санал дүгнэлтүүд болон социалист хамтын нөхөрлөлийн орнуудаас хамтран оруулсан санал, ажлын баримт бичгүүд чуулганы ажиллагааг зэвсэг хураах гол асуудлуудад хандуулан чиглүүлж, үр ашигтай санал шүүмжлэл явуулахад нөлөөлсөн бөгөөд чуулганд оролцогчдын өргөн талархал дэмжлэгийг хүлээж байв.

Чуулганд хэлэлцсэн гол асуудлууд, ялангуяа цөмийн дайны аюулыг зайлуулахтай холбогдсон асуудлаар социалист болон эвсэлд нэгдээгүй орнуудын төлөөлөгчид төсөөтэй буюу адил байр суурьтай байсан нь АНУ-тэргүүтэй НАТО-гийн гишүүн орнуудыг ганцаардмал байдалд оруулав.

Чуулганы үеэр даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг хангах, зэвсэг хураах үйл хэрэгт түлхэц болох оновчтой, тодорхой саналуудыг ЗХУ, социалист орнууд болон энхийг эрхэмлэгч бусад орон дэвшүүлэн тавьсан хийгээд анхдугаар тусгай чуулганаас гаргасан төгсгөлийн баримт бичгийн гол заалтууд хүчин төгөлдөр байгааг нотоллоо.

Зэвсэг хураах асуудлыг хэлэлцсэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн II тусгай чуулган зэвсэглэлээр хөөцөлдөх явдал улам гаарч, олон улсын

1. М. Дүгэрсүрэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн зэвсэг хураах II тусгай чуулган дээр хэлсэн үг. —«Үнэн» 1982. 6. 20.

байдал эрс хурцадсан нөхцөлд болж өнгөрснөөрөө чухам хэн зэвсэг хураах, хүн төрөлхтнийг цөмийн дайны аюулаас сэрэмжлэн зайлуулахын төлөө, хэн нь түүний эсрэг зогсож буйг яруу тод харуулснаараа чухал ач холбогдолтой болсон билээ.

Зэвсэглээр хөөцөлдөх явдлыг таслан зогсоох, цөмийн зэвсгийг устгаж, дайны аюулыг сэрэмжлэн зайлуулахын төлөө дэлхийн олон нийтийн хөдөлгөөн идэвхтэй өрнөсөн нөхцөлд тусгай чуулган болсон нь нэг талаас зэвсэг хураах асуудалд өргөн олон нийтийн анхаарлыг төвлөрүүлэх, тэдгээрийн хөдөлгөөнийг цаашид идэвхжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон нөгөө талаас сүүлийн үед эрч далайцтай болсон олон нийтийн хөдөлгөөн нь тусгай чуулганы ажиллагаанд зохих хэмжээгээр нөлөөлсөн гэдгийг тэмдэглэх хэрэгтэй юм.

Өрнөд Европ, Канад, Япон болон дэлхийн бусад өнцөг буланд өрнөсөн дайны эсрэг хөдөлгөөнийг үл өгүүлэн зөвхөн АНУ-д болсон үйл явдлын нэгэн хэсгийг дурдахад Нью-Йорк хотын төв цэнгэлдэх хүрээлэнд зургадугаар сарын 12-нд сая шахам хүний сүрт жагсаал болсон нь хэмжээний хувьд АНУ-ын түүхэнд урьд өмнө гарч байгаагүй том сүрт жагсаал юм.

НҮБ-аас гаргасан тооцоогоор дайныг эсэргүүцсэн 90 гаруй сая хүний гарын үсэгтэй баримт бичгийг НҮБ-д явуулжээ. Хүн төрөлхтний түүхэнд анх удаа АНУ-ын хэрэглэсэн цөмийн зэвсэг-атомын бөмбөгт нэрвэгдсэн Хиромиса, Нагасаки хотын төлөөлөгчид алс хол орших Японоос тус хуралд зорин ирж хурлын индэр дээрээс хүн төрөлхтөнд сүйрэл ав-чирагч цөмийн дайныг гаргуулахгүй байх, хүнийг үй олноор устгаж үлдэгсдийг эрэмдэг зэрэмдэг болгогч зэвсгийг хэзээ ч хэрэглэхгүй байхыг шаардаж хэлсэн үг хуралд оролцогчдын сэтгэл санааг гүнээ хөндлөө.

Хиромиса, Нагасакид 1945 онд хаясан атомын бөмбөгнөөс одоогийн хуримтлагдаад байгаа цөмийн зэвсгийн нийт хүч чадал сая гаруй дахин давж байгааг бодоход сэтгэл түгшихгүй байх аргагүй юм.

Анхдугаар тусгай чуулганд олон улсын болон үндэсний олон нийтийн 30 орчим байгууллага, эрдэм шинжилгээний институтийн төлөөлөгчид оролцсон бол энэ удаагийн чуулганд олон улсын ба үндэсний нийт 53 байгууллага, эрдэм шинжилгээний 23 институтийн төлөөлөгчид оролцсон нь дэлхийн олон нийт, жирийн хүмүүс цөмийн дайны аюул заналыг улам бүр ухамсарлан ойлгож, хичнээн их сэтгэл гүнээ түгшиж байгаа болон зэвсэг хураах, ялангуяа цөмийн зэвсгийг хураах үйл хэрэгт хувь нэмэр оруулан бүх хүч чадлаа нэгтгэх зориг төгөлдөр байгааг харуулж байна. Хэрэв АНУ-ын засаг захиргаа визээр боож хориг тавиагүй байсан бол дээр дурьдсан төлөөлөгчдийн тоо бүүр ч олон байхсан билээ.

Тусгай чуулган олон нийтийн хөдөлгөөнийг урьдаас илүү идэвхтэйгээр дэмжсэн нь зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн НҮБ-ын үйл ажиллагааг олон нийтийн тэмцэлтэй нягт холбох явдалд чухал ач холбогдолтой болсон юм.

БНМАУ, социалист орнууд болон дэвшилт улс түмний нэгэн адил ЗХУ-аас тус чуулганаар дээшүүлэн тавьсан чухал санаачлагыг талархан дэмжиж, тусгай чуулганыг үр дүнтэй болгохын төлөө хүчин чармайлт гаргав.

Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх Конвенц байгуулах тухай манай засгийн газраас дэвшүүлсэн санал нь олон улсын намжмал байдлыг бэхжүүлэх, улс гүрнүүдийн хооронд итгэлцэх уур амьсгалыг бий болгох зорилгоор зэвсэг хураах асуудлыг хэлэлцсэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн анхдугаар тусгай чуулганы

Төгсгөлийн баримт бичигт орсон заалтуудыг хэрэгжүүлэх болон Азийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр болж байна.

1978 онд болсон зэвсэг хураах анхдугаар тусгай чуулган дээр социалист орнууд тэрхүү хурлын эцсийн баримт бичигт тусгагдсан зэвсэг хураах салбарт явуулах үйл ажиллагааны программыг боловсруулж батлахад идэвхтэй оролцсон бөгөөд түүнээс хойших 4 жилд авсан үүргээ нэр төртэй биелүүлж ирсэн юм.

Зэвсэг хураах асуудал хэлэлцсэн анхны тусгай чуулганд БНМАУ-ын оруулсан саналын дагуу зэвсэг хураах зорилгод дөхөм үзүүлэх олон, улсын долоо хоногийг НҮБ-ыг байгуулсан өдөр жил бүрийн аравдугаар сарын 24-нөөс эхлэн зохион явуулах болсон нь өнгөрсөн дөрвөн жилд үр нөлөөтэй болж, зэвсэг хураах тэмцлийг цаашид улам өргөн хүрээ- тэй болгоход түлхэц боллоо.

Зэвсэг хураах тухай II тусгай чуулган зэвсэг хураах дэлхий дахины кампанит ажлыг зохион явуулах тухай шийдвэр гаргаж, түүндээ зэвсэг хураах зорилгод дөхөм үзүүлэх олон улсын долоо хоногийг зэвсэг хураах анхдугаар тусгай чуулганаас хойш тэмдэглэж ирсний ач холбогдлыг үнэлээд энэ арга хэмжээг цаашид үргэлжлүүлэн зохиож байх тухай заалт орууллаа.

Ийм шийдвэр гаргахад манай улс зохих хувь нэмэр оруулсан бөгөөд дайныг эсэргүүцсэн олон нийтийн хөдөлгөөн улам бүр өрнөж байгаа өнөөгийн нөхцөлд манай санаачилгын ач холбогдол бүр ч их болж байна.

Тусгай чуулганы ерөнхий шүүмжлэл дээр БНМАУ-ын Гадаад явдлын яамны сайд М. Дүгэрсүрэн хэлсэн үгэндээ дайныг эсэргүүцсэн олон нийтийн хөдөлгөөн дэлхий дахинд, ялангуяа Европ тивд болон АНУ-д улам бүр өсөн нэмэгдэж байгааг БНМАУ талархан дэмжиж байна. Энэ нь дэлхийг нөмөрсөн дайны аюулыг улс түмэн улам бүр ухамсарлаж, цөмийн сүйрлийг сэрэмжлэн зайлуулах шийдвэр төгс байгааг нотолж байна гэж онцлон тэмдэглэсэн билээ.

Өнөөгийн олон улсын нөхцөл байдалд энх тайвныг эрхэмлэгч бүх хүчний нэгдэл нягтрал, хамтын ажиллагааг бэхжүүлэх явдал урьд урьдаас илүү ач холбогдолтой болж байгаа бөгөөд социалист орнууд дайны эсрэг олон нийтийн хөдөлгөөнийг энх тайвны төлөө үйл хэргийг урагшлуулах чухал хүчин зүйл гэж үзэж сайшаан дэмжиж байна.

II СПЕЦИАЛЬНАЯ СЕССИЯ ГЕНЕРАЛЬНОЙ АССАМБЛЕИ ООН ПО РАЗОРУЖЕНИЮ

(Р е з ю м е)

II специальная сессия Генеральной Ассамблеи ООН по разоружению была созвана по инициативе ООН в связи с растущей опасностью ядерной войны, увеличением гонки вооружений и обострением напряженности во многих регионах мира. Созыв сессии имеет особое значение в данный период, когда по вине США и их союзников по НАТО вследствие их провокационного политического курса, направленного на подрыв разрядки и сведения на нет положительных результатов, достигнутых в международных отношениях прошлых лет, резко обострилась международная обстановка. Однако из-за обструкционистской позиции занятой представителями США и ряда западных стран II специальная сессия Генеральной

Ассамблеи ООН не смогла принять конкретных решений по ряду вопросов, направленных на обуздание гонки вооружений.

Советский Союз и другие социалистические страны вновь продемонстрировали принципиальность своей внешней политики, отвечающей интересам всех миролюбивых народов. Послание Л.И.Брежнева Генеральной Ассамблее содержало новое историческое предложение об отказе СССР первым применить ядерное оружие. Конструктивная инициатива Советского Союза явилась еще одним доказательством великой заботы, проявляемой СССР к судьбам народов мира, сознанием большой ответственности, лежащей на каждой стране по обеспечению мировой безопасности неукланного следования принципам миролюбивой ленинской политики.

Предложения Советского Союза, содержащиеся, в послании Л.И.Брежнева были поддержаны и горячо встречены представителями большинства государств, участвовавших в работе сессии.

МНР совместно с другими социалистическими странами последовательно и целенаправленно выступает за конструктивный подход к решению важных, неотложных проблем по смягчению международной напряженности, обузданию гонки вооружений, отхода от политики «холодной войны» в международных отношениях, за обеспечение стабильности и безопасности на нашей планете.